

Тайлангийн маягт, түүнийг нөхөх заавар

батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.6.2 дахь заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан” ТТ-17(1) маягтыг 1 дүгээр, “Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан /Маягт ТТ-17(1)-гийн хавсралт мэдээ”-г 2 дугаар, “Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан” ТТ-17(1) нөхөх заавар”-ыг 3 дугаар, “Усны нөөц ашигласны төлбөрийн тайлангийн хавсралт мэдээг нөхөх заавар”-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шинээр батлагдсан тайлангийн маягтын дагуу 2019 оны 4 дүгээр улирлын тайлант хугацаанаас эхлэн тайлан, мэдээг сум, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүлээн авч төлбөрийн тооцоо хийхийг аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, тайлангийн маягт, мэдээг цахим тайлангийн системд нэвтрүүлэхийг Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2012 оны А/907 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус, рашаан ашигласны төлбөрийн тайлангийн маягт ТТ-17А,Б, нөхөх заавар”-ыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



ТӨСӨЛ

ТЕГ-ын даргын 2019 оны ... сарын ...өдрийн
..... тоот тушаалын хавсралт

Монголын Татварын Алба

Маягт ТТ-17

Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан

Татварын жил: [][][][]

/он/

Тайлант хугацаа: [][][][] –ээс [][][][]-ыг дуустал
сар,өдөр сар,өдөр

Татвар төлөгчийн мэдээлэл:

ТТ-ийн дугаар: [][][][][][][][][][]

Утас: [][][][][][][][][][][][]

ТТ-ийн нэр: _____

Факс: [][][][][][][][][][][]

Аймаг, хот: _____

Шуудангийн хайрцаг: _____

Сум, дүүрэг: _____

И-мэйл хаяг: _____

Баг, хороо: _____

Эрхлэх үйл ажиллагааны
чиглэл: _____

Хороолол: _____

Салбарын ангиллын код: _____

Гудамж, байшин: [][][][]

Толгой компаний регистрийн
дугаар: [][][][][][][][]

Хашаа, тоот: [][][][]

Татварын албаны мэдээлэл:

Татварын төрлийн код: [][][][][][][]

Татварын албаны код: _____

Тайлангийн үечлэл: _____

Тайлант үе: _____

Татварын байцаагч: _____

Хүлээн авсан огноо: _____

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол [✓] энд тэмдэглэнэ үү.

Б:Төлбөр ногдуулалтын тооцоолол

(жилээр,төгрөгөөр)

Төлбөр ногдох ус	Мөр	Хэмжих нэгж	Төлбөр төлөгчийн тоо	Ашигла сан усны хэмжээ	Ногдуулсан төлбөрийн дүн	Хөнгө лөлт	Чөлөө лөлт	Нийт ногдуулсан төлбөрийн дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Хүн амын унд, ахуйн зориулалт		шоо мет р						
Хүнд үйлдвэр								
Барилга, барилгын материалын үйлдвэрлэл								
Авто зам, засварт ашигласан								
Хөнгөн үйлдвэр								
Хүнсний үйлдвэрлэл								
Уул уурхайн үйлдвэрлэл								
Эрчим хүчний үйлдвэрлэл								
Газар тариалангийн үйлдвэрлэл								
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн төлбөр								

төлөгчийн ашигласан ус								
Усан цахилгаан станц		төг						
Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх								
Усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, аялал, зугаалга, усан спортын байгууламж								
Дүн								

В:Төлбөрийн тооцоолол

Дт

Кт

Тайлангийн эхний үлдэгдэл	Илүү	1		
	Дутуу	2		
Тайлант хугацаанд ногдуулсан төлбөр	Илүү	3		
	Дутуу	4		
Тайлант хугацаанд дансаар төлсөн		5		
Татварын алба болон татвар төлөгч хоорондын тооцоогоор төлсөн		6		
Тайлангийн хугацаанд төсвөөс буцаан авсан		7		
Тайлант хугацаанд хүлээн авсан үлдэгдэл	Илүү	8		
	Дутуу	9		
Тайлант хугацаанд шилжүүлсэн үлдэгдэл	Илүү	10		
	Дутуу	11		
Тайлант хугацаанд хүчингүй болгосон		12		
Суутган тооцоолсон	Илүү	13		
	Дутуу	14		
Тайлангийн эцсийн үлдэгдэл		Илүү	15	
		Дутуу	16	

Тайланг үнэн зөв гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Эрх бүхий албан тушаалтан

.....татварын хэлтсийн

..... /...../

ТУБ...../...../

20 оны сарын өдөр

Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан ТТ-17
маягт нөхөх заавар

Монгол улсын байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль-ийн 23 дугаар зүйлийн 23.2-д заасны дагуу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тайланг энэхүү маягтаар дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тайлагнах үүрэгтэй. Байгалийн нөөц ашигласан төлбөр хураан авах эрх бүхий албан тушаалтан нь энэ тайлангийн маягтаар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан 10.1.1-10.1.3 хүртэлх төлбөр тооцох үзүүлэлтээр ашигласан усны нөөцийн төлбөрийг ногдуулж, тайлант хугацааны төлбөрийн тайланг гаргана.

1. Тайлангийн маягт нь 3 үндсэн хэсэгтэй бөгөөд “А” хэсэг нь тухайн төлбөр төлөгчийн талаарх нийтлэг мэдээлэл, “Б” хэсэгт төлбөр ногдуулалтын тооцоолол, “В” хэсэг нь тайлант хугацааны төлбөрийн ногдуулалтын тооцоолол гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.
2. Төлбөр ногдох ус /багана-1/ нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу тодорхойлно.
3. Хэмжих нэгж /багана-3/ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар тодорхойлогдоно.
4. Төлбөр төлөгчийн тоо /багана-4/ нь хавсралт мэдээний багана 4, багана 6-ийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.
5. Ашигласан усны хэмжээ /багана-5/ нь ТТ-17(А) маягтын хавсралт мэдээний багана 11, багана 16-ийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.
6. Ногдуулсан төлбөрийн дүн /багана-6/ нь ТТ-17(А) маягтын хавсралт мэдээний багана 18-ийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.
7. Хөнгөлөлт чөлөөлөлт /багана-7/ нь ТТ-17(А) маягтын хавсралт мэдээний багана 19-ийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.
8. Нийт ногдуулсан төлбөрийн дүн /багана-8/-г ногдуулсан нийт төлбөрийн дүн /багана 6/-гээс хөнгөлөлт чөлөөлөлтийг /багана 7 /хасаж гаргах ба ТТ-17(А) маягтын хавсралт мэдээний багана 20-ийн нийлбэр дүнтэй, тэнцүү байна.

“МАЯГТ, ТАЙЛАН НӨХӨХ ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ” ТУШААЛЫН ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

2.1.1. Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох

Татварын ерөнхий газрын даргын 2012 оны А/907 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус, рашаан ашигласны төлбөрийн тайлангийн маягт ТТ-17А,Б, нөхөх заавар”-ын төлбөр төлөгч бүрээр нгдуулсан төлбөрийг гаргах хавсралт мэдээгүй, рашаан ашигласны төлбөрийг хавсралт мэдээ хэлбэрээр гаргадаг тул төлбөр төлөгч бүрээр төлөлтийг гаргах боломжгүй, тодорхой мэдээ, судалгаа гаргах, татварын алба хяналт тавих боломжгүй тул ус ашигласны төлбөр, рашаан ашигласны төлбөрийг салган тайлагнах, төлбөр төлөгч бүрээр мэдээг задлан ирүүлдэг болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хяналт тавих зорилгоор байгалийн баялаг ашигласны төлбөрийн тайлангийн маягтыг шинэчлэх, мэдээний маягт боловсруулан гаргах шаардлага үүссэн.

Иймд Татварын ерөнхий хуулийн 27¹ дугаар зүйлийн 27^{1.6.2} дахь заалт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тайлангийн маягт, түүний хавсралт, нөхөх зааврын төслийг боловсруулав.

2.1.2. Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тухайн тушаалаар 4 хавсралтаас бүрдсэн эрх зүйн баримт бичиг батлагдана. Үүнд:

- Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан ТТ-17(1) маягт
- Усны нөөц ашигласны төлбөрийн тайлангийн хавсралт мэдээ
- Усны нөөц ашигласны төлбөрийн тайлан нөхөх заавар
- Усны нөөц ашигласны төлбөрийн тайлангийн хавсралт мэдээг нөхөх заавар”

Эдгээр эрх зүйн баримт бичиг бүрийн дээд хэсэгт Татварын ерөнхий газрын даргын тушаалын батлагдсан огноо, дугаар тэмдэглэгдсэн, Татварын ерөнхий газрын тамга дарагдаж баталгаажсан, тухайн баримт бичгийн гарчигтай байна.

Энэхүү тайлан болон мэдээний маягтаар хуульд төлбөр хураан авах эрх бүхий албан тушаалтан тайлан гаргаж, албан татварын тооцоо хийнэ.

2.1.3. Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох

Батлагдсан маягтаар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан байгалийн нөөц ашигласны төлбөр ногдуулан төлүүлэх эрх бүхий аймаг, сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан тайлан гаргаж ирүүлэх тул Байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас санал авч тусгасан, тайлан гаргахад хялбар, төлбөр төлөгч бүрийг хавсралтаар гаргах тул татвар төлөгчдийн хэрэгцээнд нийцсэн болно.

2.1.4. Хүний эрх, эрх чөлөө өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал,

авилга гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Уг тушаалаар батлагдсан маягт нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай тухай хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд эрх бүхий мэргэжилтэн тайлагнахад хялбар байхаар зохицуулагдан боловсруулагдсан, хүний эрх, эрх чөлөө өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авилга гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

2.1.5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болно.

2.1.6. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник эдийн засгийн тооцоо

Тушаалаар батлагдах маягтаар усны нөөц ашигласны төлбөр ногдуулан төлүүлэх эрх бүхий албан тушаалтан төлбөрийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сум, дүүргийн татварын албанд жилд нэг удаа цахимаар гарган ирүүлэх бөгөөд үүнтэй холбогдуулан хүний нөөц, техник эдийн засгийн тооцоог шинээр хийх шаардлагагүй болно.

ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ ХАРИЛЦАХ
ГАЗРЫН ДАРГА

Д.ЦОГЗОЛМАА

**“МАЯГТ, ТАЙЛАН НӨХӨХ ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ”
ТУШААЛЫН ТӨСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Татварын ерөнхий газар нь Татварын удирдлагын нэгдсэн системд шилжсэнээр татвар төлөгчийн бусдад суутгуулж төлсөн албан татвар, төлбөр, хураамж тухайн татвар төлөгчийн мэдээлэл рүү илгээгдэж, татвар төлөгч бүх хэлбэрээр төлсөн албан татвараа харах, хянах боломжтойгоор шийдвэрлэсэн бөгөөд энэ зорилтын хүрээнд суутгагч татвар төлөгч нь суутгуулагчдын мэдээллийг бүрэн тайлагнах, мөн ус ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор ус ба рашааны төлбөрийн тайланг салган тайлагнуулах шаардлага үүссэн.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөр төлсөн хувь хүн, хуулийн этгээдийн төлбөрийн мэдээлэл нь Татварын ерөнхий газрын даргын 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр А/907 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус, рашаан ашигласны төлбөрийн тайлангийн маягт ТТ-17А,Б, нөхөх заавар” маягтад бүрэн харагдах боломжгүйн дээр уг маягтаар рашааны төлбөрийн тайланг хавсралт хэлбэрээр гаргадаг байсан тул салгаж тайлагнуулах, тайлан гаргах мэргэжилтнүүдэд ойлгомжтой, төлбөр төлөгч бүрээр гаргадаг хавсралт мэдээтэй болгох нь зүйтэй гэж татвар төлөгчдийн хэрэгцээнд үндэслэн Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, татварын улсын /ахлах/ байцаагчид хэлэлцэн шийдвэрлэсэн.

Уг тайлангийн болон мэдээний маягт батлагдсанаар төлбөр ногдуулан төлүүлэх, тайлан гаргах үүрэг бүхий мэргэжилтэнд тайлан гаргахад илүү тодорхой, ойлгомжтой байх, төлбөр төлөгч өөрийн төлсөн төлбөрийг харах, хянах, татварын алба мөн ногдуулалт, төлөлт, тайлагналд хяналт тавих, шаардлагатай мэдээ судалгаа бүрэн, зөв гарах нөхцөл бүрдэнэ.

ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ ХАРИЛЦАХ
ГАЗРЫН ДАРГА Д.ЦОГЗОЛМАА